

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

**Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсныг
дэмжин баталгаажуулах тухай**

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Иргэний хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.20, 8.11.26 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Худалдаа, хөгжлийн банк болон түүний холбогдох этгээдүүдтэй байгуулсан энэхүү тогтоолын хавсралт 1-т заасан нөхцөлтэй дараах хэлцлүүдийг хүлээн зөвшөөрч, Иргэний хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийг удирдлага болгон хүчин төгөлдөр байдлыг дэмжин баталгаажуулсугай.

- 1.1. “Ти Ди Би Капитал” ХХК-тай 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан TDBM/39/2025 дугаартай “Хамтран ажиллах гэрээ”;
- 1.2. “Монголийн Нэшнл Рийр Ийрт Корп” ХХК-тай 2025 оны 2 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан TDBM/37/2025 дугаартай “Хамтран ажиллах гэрээ”;
- 1.3. Луксор Интернэйшнл ХХК-тай 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан TDBM/38/2025 дугаартай “Хамтран ажиллах гэрээ”.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА




РАНДОЛФ КОППА